



И-Х/2022

Тархаасан: 2022 оны 11 дүгээр сарын 15



Барилга угсралт, их засварын ажил 2022 оны эхний 9 сард 30.5 хувиар өслөө

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2022 оны эхний 9 сард 4.6 их наяд төгрөг болж, 4.5 (97.5%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 115.2 (2.5%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.


ХҮСНЭГТ 1. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, гүйцэтгэгчийн төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлт	2019 И-Х	2020 И-Х	2021 И-Х	2022* И-Х	<u>2022* И-Х</u> 2021 И-Х
	тэрбум төгрөг				хувь
Нийт	3 929.4	4 328.7	3 508.6	4 580.0	130.5
Дотоодын байгууллага	3 667.9	4 243.1	3 421.5	4 464.9	130.5
Төрийн	89.8	388.7	264.4	103.9	39.3
Хувийн	3 558.5	3 794.5	3 120.5	4 324.0	138.6
Гадаадтай хамтарсан	19.6	59.8	36.6	37.0	101.0
Гадаадын байгууллага	261.5	85.6	87.2	115.2	132.1

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2022 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 1.1 (30.5%) их наяд төгрөгөөр өсөхөд дотоодын байгууллагын барилгын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 1.0 (30.5%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Дотоодын барилгын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 4.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.2 (38.6%) их наяд төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагынх 37.0 тэрбум төгрөг болж, 366.0 (1.0%) сая төгрөгөөр өслөө. Харин төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 103.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 160.5 (60.7%) тэрбум төгрөгөөр тус буурсан байна.

ЗУРАГ 1. БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, төрлөөр, тэрбум төгрөг, жил бүрийн эхний 9 сарын байдлаар




Энэ оны эхний 9 сард барилга угсралт, их засварын ажлын 38.5 хувийг орон сууцны барилга, 28.2 хувийг орон сууцны бус барилга, 30.1 хувийг инженерийн барилга, байгууламж, 3.2 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оны мөн үеэс орон сууцны барилгын ажлын эзлэх хувь 2.4 нэгж хувиар, их засварын ажлынх 0.7 нэгж хувиар, инженерийн барилга, байгууламжийнх 1.4 нэгж хувиар тус тус өссөн бол, орон сууцны бус барилгынх 4.5 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 2. ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭЛ, төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлт	2019 I-X	2020 I-X	2021 I-X	2022* I-X	<u>2022* I-X</u> 2021 I-X
	тэрбум төгрөг				хувь
Орон сууцны бус барилга	1 805.4	1 457.9	1 148.0	1 290.4	112.4
Үйлдвэрийн	937.3	536.1	564.3	496.3	88.0
Худалдаа, үйлчилгээний	104.8	125.2	99.9	143.2	143.3
Эмнэлгийн	102.0	75.6	46.7	51.8	110.9
Сургууль, соёлын	420.4	441.1	275.2	313.1	113.8
Бусад	240.9	279.9	161.9	285.9	176.7

Орон сууцны бус барилгын ажлын гүйцэтгэл 2022 оны эхний 9 сард 1.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 142.4 (12.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд үйлдвэрийн барилгын ажил 68.0 (12.0%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч сургууль, соёлын барилгын ажлынх 37.9 (13.8%) тэрбум төгрөгөөр, худалдаа, үйлчилгээний барилгын ажлынх 43.3 (43.3%) тэрбум төгрөгөөр, бусад орон сууцны бус барилгынх 124.1 (76.7%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 5.1 (10.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 2. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, тэрбум төгрөгөөр



Улаанбаатар хотод 2022 оны эхний 9 сард 2.0 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 45.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.7 нэгж хувиар өссөн байна.

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2022 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр Дорноговь

аймагт 941.6 тэрбум төгрөг, Өмнөговь аймагт 601.2 тэрбум төгрөг, Орхон аймагт 146.1 тэрбум төгрөг, Дархан-Уул аймагт 114.8 тэрбум төгрөг болж, энэ нь аймгуудын барилга угсралтын ажлын дүнд 40.4 хувийг эзэлж байна. Дорноговь аймагт Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын барилгын ажил, Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт Оюу толгойн далд уурхайн ажил, төмөр зам болон автозамын ажлууд, Дархан-Уул аймагт автозамын ажлууд, Орхон аймагт Эрдэнэт үйлдвэрийн барилгын өргөтгөлийн ажил, орон сууцны барилга зэрэг ажлууд эрчимтэй хийгдсэн байна.

Ойлголт, тодорхойлолт

Барилга угсралт, их засвар гэж барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг ойлгоно.

Орон сууцны барилга нь хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламж юм.

Орон сууцны бус барилгад барилгын багахан хэсгийг (нийт талбайн 50%-иас бага хэсэг) орон сууцны зориулалтаар ашигладаг барилгыг оруулна.

Инженерийн барилгын ажилд төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, ус хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга байгууламжийн бүх ажлыг оруулна.



Тайлбар: ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр:

ҮСХ, Барилга байгууламж, объектын улирлын мэдээ (ББО-1)

Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2023 оны 2 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын дарга

А.Дэмбэрэл

Утас : (976-51)-329278

Эдийн засгийн статистикийн газрын Хөдөө

аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн

статистикийн хэлтсийн статистикч

Л.Шинэтуяа

Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212